







8-р анги

А. Сонгох даалгавар

- 64 бит хэдэн байт болох вэ?
А. 4 байт Б. 8 байт В. 16 байт Г. 32 байт
 - Аль нь үйлдлийн систем биш вэ?
А. Windows 8 Б. Linux В. Windows Explorer Г. Ubuntu
 - Үйлдлийн систем болон төхөөрөмжийн үзүүлэлт бүхий мэдээллийг харахдаа аль командыг сонгох вэ?
А. CTRL+ R / DxDiag Б. WINDOWS LOGO+ R / DxDiag
В. ALT+ R / DxDiag Г. SHIFT+ R / DxDiag
 - Нөхцөлөөс хамааран хийх үйлдлээ сонгон хэрэгжүүлдэг алгоритмыг алгоритм гэнэ.
А. Шугаман Б. Салаалсан В. Давталтай
 - Яст мэлхийн урлан программ дээр дүрсэлсэн дараах алгоритмын үр дүн аль нь вэ?
А.  Б.  В.  Г. 
- 
- INSERT цэсний CHART команд ямар үүрэгтэй вэ?
А. Зураг засварлах Б. Хүснэгттэй ажиллах
В. График байгуулах Г. Диаграмм оруулах
 - Аль нь А4 цаасны хэмжээ вэ?
А. 4,13" x 5,83" Б. 5,83" x 8,27" В. 8,27" x 11,69" Г. 11,69" x 16,54"
 - Paint.net программ дээр үүсгэгдсэн файл аль нь вэ?
А. Zurag.pdn Б. Zurag.psd В. Zurag.pdf Г. Zurag.png
 - Paint net программын Image/crop to selection командын үүрэг
А. Зургийг устгах Б. Зургийг тайрах В. Зургийг хуулах Г. Зургийг эргүүлэх
 - Танилцуулгын идэвхтэй байгаа хуудсыг тоглуулахын тулд гараастовчны хослолыг дарна.
А. Shift+F5 Б. Alt+F5 В. Ctrl+F5 Г. Fn+F5

- 11. Зурагт үзүүлсэн Hyperlink командын үүрэг аль нь вэ?

- Зурагт үзүүлсэн Hyperlink командын үүрэг аль нь вэ?
А. Шинэ бармт үүсгэх Б. Объектод хөдөлгөөн оруулах
В. Слайданд хөдөлгөөн оруулах Г. Холбоос хийх
- Merge&Center командын үүрэг
А. Нүднүүдийг нэгтгэнэ Б. Нүднүүдийг устгана
В. Нүднүүдийг нэмнэ Г. Нүднүүдийг сонгоно
- =Sum(A5;A8) функц ямар утга буцаах вэ?
А. А5-аас А8 мужийн нийлбэр олно Б. А5-аас А8 мужийн ялгавар олно
В. А5,А8 мужийн нийлбэр олно Г. А5,А8 мужийн ялгавар олно
- Мэдээллийг хамтран эзэмших дараах ач холбогдлуудаас аль нь илүүц вэ?
А. Богино хугацаанд мэдлэг, чадвараа дээшлүүлж, түршлага хуримтлуулж болно.
Б. Хүн бүрийн оролцоог хангаж, аливаа шийдвэрийг оновчтой гаргадаг.
В. Дурын мэдээллийг олон нийтэд нийтлэх, түгээх, зөвшөөрөлгүй тараах асуудал юм.
Г. Бүрэн бус, баталгаагүй, буруу ташаа мэдээллийг бусадтай хуваалцаж болохгүй.

Б. Задгай даалгавар

Таван хошуу мал гэдэг нь монголчуудын эртнээс нааш гаршуулан өсгөн, ашиг шимийг нь хүртэж буй **адуу, үхэр, тэмээ, хонь, ямааг** ерөнхийд нь нэрлэн хэлсэн үг юм.

Эртнээс нааш Монгол түмний гол амин зуулга нь мал аж ахуй болж ирсний хувьд монгол зон олон таван хошуу малаа их дээдэлдэг бөгөөд таван хошуу малыг нийтэд нь мөн таван эрдэнэ хэмээн хэлдэг.

Адуу, үхэр, тэмээ гурвыг **бод мал** гэх бөгөөд хонь ямааг **бог мал** гэнэ. Адууны төлийг **унага**, тэмээний төлийг **ботго**, үхэрний төлийг **тугал**, хонины төлийг **хурга**, ямааны төлийг **ишиг** гэдэг.

Эх газрын эрс тэс, экологийн нөхцөлд байгалийн урт хугацааны шалгарал, мал маллагааны олон зууныг дамжиж ирсэн ардын сонгон үржүүлгийн үр дүнд байгаль-цаг уурын хатуу ширүүн нөхцөлд дасан зохицож ,биологийн онцгой

шинжийг хадгалсан нутгийн монгол мал бий болсон юм. Монгол үүлдрийн мал нь жилийн дөрвөн улиралд бэлчээрийн маллагаанд байж, үржин төлжиж ашиг шимээ өгсөөр ирсэн уламжлалтай билээ.

Даалгавар: Дээрх эхийг ашиглан дараах асуултуудад хариулна уу.

1. Дээрх эхээс 4 байтад багтаан хадгалж болох мэдээ 5-ыг бичнэ үү.

- 1.....
- 2.....
- 3.....
- 4.....
- 5.....

2. Дараах хүснэгтийг MS Office Excel программ дээр хийж, гүйцээн нөхнө үү. Documents дотор өөрийн нэртэй хавтас үүсгэн **husnegt** нэртэйгээр хадгална уу.

Д/д	Таван хошуу мал	Бог мал	Бод мал	Үр төл
1	Адуу			
2	Үхэр			тугал
3	Тэмээ			
4	Хонь			
5	Ямаа			

3. Дээрх эхийг MS Office Word программ дээр форматын дагуу бичиж Documents дотор өөрийн нэртэй хавтас дотор **tavan hoshuu mal** нэртэйгээр хадгална уу.

4. Таван хошуу малын төл малаас нэгийг сонгож Paint.net программ дээр зурж, Documents дотор өөрийн нэртэй хавтас дотор **tol mal** нэртэйгээр хадгална уу.

5. Дээрх эхийг ашиглан MS Power Point программ дээр 4 хуудастай танилцуулга бэлтгэнэ үү.

- Хуудас бүрт хөл, толгойн мэдээлэл оруулаарай
- Слайд бүрт хөдөлгөөн оруулаарай
- Объект бүрт хөдөлгөөн оруулаарай

- Бэлтгэсэн танилцуулгаа Documents дотор өөрийн нэртэй хавтас дотор **taniltsuulga** нэртэйгээр хадгална уу.

6. Бат зуны амралтаараа дарсан зурагнуудаа 1 гигабайт хэмжээтэй флаш дискэнд хуулсан боловч зурагнуудын хэмжээ 1 гигабайтаас их тул багтахгүй байлаа. Уг асуудлыг хэрхэн шийдэж болох вэ?

.....
.....

7. Дараах илэрхийллийг бодох үйлдлийн дарааллыг тодорхойлоорой.

$$(5+3)*(10-4)-(10+2)/(18-6)=$$

1.
2.
3.
4.
5.
6.
7.

8. Нийгмийн сүлжээ буюу фэйсбоок, твиттерийг ашиглахад анхаарах зүйлсүүдээс дурдана уу.

Жишээ нь: *Баталгаагүй худал мэдээ мэдээллийг тарааж болохгүй*

-
-
-
-
-